

**АВТОМАШИН ЗЭЭЛЭЭР
ХУДАЛДАХ ,ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

201... оны ...-р сарын ... ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй *Тахько ХХК* (цаашид “Худалдагч” гэх), нөгөө талаас (цаашид “худалдан авагч “ гэх) бид нар Монгол улсын Иргэний хуулийг үндэслэн дараахь нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1 Гэрээний зорилго нь худалдан авагчийн захиалсан автомашиныг зээлээр худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулахд оршино.
- 1.2 Талууд энэхүү гэрээтэй холбоотой харилцаанд бие биенийхээ эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж, харилцан ашигтай харилцааг эрхэмлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх зарчмыг удирдлага болгоно.
- 1.3 Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, НӨХЦӨЛ

- 2.1. Энэхүү гэрээ нь 201... оны ...-р сарын ...-ны өдрөөс 201... оны ...-р сарын ...-ны өдрийг дуустал сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.

ГУРАВ . НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1 Энэ гэрээнд хэрэглэгдсэн дараахь нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно
 - “Холбогдох хууль тогтоомж” гэдэгт энэ гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль, бусад эрх зүйн актыг
 - “Худалдах үнэ” гэдэгт автомашин худалдах ба худалдан авах үнийг

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭДЛЭХ ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 4.1 Энэхүү гэрээний 1.1-т заасныг хэрэгжүүлэхийн тулд талууд дараах үүргийг харилцан адил хүлээж, дор дурдсан эрхийг эдэлнэ. Үүнд:

Талуудын хүлээх үүрэг:

- Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх
- Гэрээг байгуулах болон хэрэгжүүлэх явцад албан болон албан бусаар мэдсэн байгууллагын нууцыг чандлан сахих
-

Талуудын эдлэх эрх :

- Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг харилцан шаардах
-

ТАВ. ХУДАЛДАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 Худалдагч тал дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 5.1.1 Зээлээр автомашин борлуулахад шаардлагатай мэдээ мэдээллийг Худалдан авагч байгууллагаас гаргуулах Үүнд:

- Аж ахуйн нэгж байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн

Үргэлжлэл бий